



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 39

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 346,788,858 /гурван зуун дөчин зургаан сая долоон зуун наян найман мянга найман зуун тавин найм/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй хавсралтад дурьдсан барилга байгууламжийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (С.Оюунболд)-д даалгасугай.

Гурав. Барилгыг буулгах зөөх ажлын хөлсөнд барилгын материалыг үнэлж зарцуулахыг дурдсугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С. СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 23 дугаар сарын
23-ний өдрийн 42 тогтоолын хавсралт

Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын актлаж, данснаас хасах барилга байгууламжийн мэдээлэл

№	Барилга. байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Тоо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өргөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ							
1	Дотуур байр	Хүүхдийн байр	ш	60	1986	34	1	147406170	147406170	-	
2	Склад	Склад	ш	154	1951	69	1	2901192	2901192	-	
3	Орон сууц 1940	4 айл	ш	131	1940	80	1	43904700	43904700	-	
4	Склад 1940/шоон/	Склад	ш	111	1940	80	1	4737860	4737860	-	
5	Үйлчилгээний байр 1962	Склад	ш	224	1962	58	1	147838936	147838936	-	
								346,788,858 /гурван зуун дөчин зургаан сая долоон зуун наян найман мянга найман зуун тавин найман төгрөг/	346,788,858 /гурван зуун дөчин зургаан сая долоон зуун наян найман мянга найман зуун тавин найман төгрөг/		

Нийт дүн

Ed